



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2023 оны 11 дугаар сарын 28

Дугаар 4

Улаанбаатар хот

IV ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын хуралдаан 2023 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 09.00 цагт Төрийн ордон дахь “Шадар сайдын албан өрөө”-нд 7.8.9 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Бензин, газрын тосны бүтээгдэхүүний импорт, цаашдын төлөв байдлын талаар
*Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар*
2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилтийн нөхцөл байдлын талаар
*Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун*
3. Эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, үр дүнгийн талаар
*Эрчим хүчний сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн*
4. Цаг агаарын төлөв байдлын талаар
*Цаг уур, орчны шинжилгээний газрын даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч Л.Оюунжаргал*
5. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэлийн Онцгой комисс, бүх шатны Засаг дарга нарт:

1.1. Өвөлжилт хүндрэх, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлийн үед хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийг хамгаалах, эрсдэлийг бууруулах, иргэдэд эрүүл мэндийн болон төрийн бусад үйлчилгээг шуурхай тасралтгүй хүргэх төлөвлөлтийг нарийвчлан гаргаж, шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг бүх шатанд авч хэрэгжүүлэх;

1.2. Хоол хүнс, эм, эмнэлгийн хэрэгсэл, шатахуун, түлш зэрэг гамшгийн бэлэн байдлын нөөцийг орон нутгийн хэмжээнд тодотгож, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

1.3. Цаг уурын байгууллагаас гаргаж буй бэлчээрийн даац, зудын эрсдэлийн зураглал, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн сэрэмжлүүлэг мэдээ, аймаг, сумдын Онцгой комиссын үйл ажиллагаа, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллийг иргэдэд шуурхай хүргэх;

1.4. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээлийн нөөцийг нэмж бүрдүүлэх, өвс, тэжээлийн зах зээлийн нөөцийн судалгааг гаргаж, олон нийтийг мэдээллээр хангах;

1.5. Малын шилжилт хөдөлгөөн, отор нүүдлийг Засаг дарга нарын хооронд байгуулсан гэрээ, санамж бичгийг үндэслэн зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

1.6. Отроор явж буй малчин өрхийн судалгааг нарийвчлан гаргаж, тухай бүр тодотгож, эрүүл мэндийн болон бусад тусламж үйлчилгээг үзүүлэх, аливаа эрсдэлийг бууруулах арга хэмжээнд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

1.7. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 51 дүгээр зүйлд “Төсвийн ерөнхийлөн захирагч нь жил бүрийн төсвийн багцдаа гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг төлөвлөж, зардлыг тусгана”, “Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд аймаг, сум, нийслэл, дүүрэг, төрийн байгууллага тухайн жилийн төсвийнхөө 1.0 хувиас доошгүйг зарцуулахаар тооцон төсөвт тусгаж, хуулийн этгээд тухайн жилийн үйлдвэрлэл, үйлчилгээний зардлын 1.5 хувиас доошгүй хэмжээний хөрөнгийг төлөвлөж зарцуулна” гэж заасныг мөрдлөг болгон 2024 оны төсөвт гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны зардлыг бодитоор тооцож тусгах;

1.8. Цас их орж, шуурсны улмаас орон нутгийн авто замууд хаагдах, иргэд, малчид зорчиход хүндрэлтэй нөхцөл байдал тогтмол үүсэж байна. Иймд хаагдсан зам давааг нээх, зорчих хөдөлгөөнийг хэвийн явуулах арга хэмжээг тухай бүр авч хэрэгжүүлэх;

Хоёр. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Х.Болорчулуун, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга А.Нарантуяа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Мал, махны экспортыг нэмэгдүүлэх, баруун аймгуудын малын тэжээлийн импортод дэмжлэг үзүүлэх, өвс тэжээлийн зах зээлийн нөөцийн судалгааг гаргаж олон нийтийг мэдээллээр хангах, хяналт тавьж ажиллах;

2.2. Цаг уур, орчны шинжилгээний байгууллагаас Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу зудын байдалд үнэлгээ хийхэд 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 10 аймгийн 22 сум цагаан зудтай, 8 аймгийн 26 сум цагаанаар зудархуу нөхцөлд шилжсэн байна. Цаашид өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх төлөвтэй энэ цаг үед тэжээлийн олдоц хангалтгүй, үнэ ханш нэмэгдсэн, зарим аймгийн нутагт мал бэлчээрлэх боломжгүй болсон зэргийг харгалзаж дотоодын тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх, шаардлагатай тохиолдолд тэжээлийн экспортыг түр хугацаанд зогсоох эсэх асуудлыг судалж шийдвэрлэх;

2.3. Аймаг, орон нутгийн удирдлага, мах бэлтгэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдтэй хамтран мал, махыг эдийн засгийн эргэлтэд оруулах, шаардлагатай дэмжлэгийг үзүүлэх зэргээр нэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээг орон нутагт авч хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.4. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчний эрсдэл өндөртэй байгаа Дорнод, Хэнтий, Сүхбаатар, Булган аймгийн өвчлөмтгий бүх малыг дархлаажуулахад шаардагдах вакцины нөөц бүрдүүлж, яаралтай дархлаажуулах ажлыг 2023 онд багтааж шуурхай зохион байгуулах, ажлын явц, үр дүнг танилцуулж ажиллах;

2.5. Өвөлжилт, хаваржилт хүндэрч болзошгүй байгаатай холбогдуулан малын эм ханган нийлүүлэх байгууллагатай хамтран малыг тэнхрүүлэх нэмэлт бэлдмэлийн нөөц бүрдүүлэх, ариутгал халдваргүйтгэлийн бодис, хамгаалах хувцас хэрэглэлийг нөөц бүрдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

Гурав. Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний жанжин штабын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал С.Ганбямба, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Х.Лхагвасүрэн нарт:

3.1. Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 68 орчим хувьд цасан бүрхүүл тогтож, зарим аймгийн нутгаар цагаан зудтай, цагаанаар зудархуу нөхцөл байдалд шилжсэн тул шаардлагатай тохиолдолд дайчлан гаргах албан хаагч, туулах чадвар сайтай автомашин, техникийн бэлэн байдлыг хангах, аймаг, орон нутгийн Онцгой комисст тухай бүр шуурхай дэмжлэг үзүүлж ажиллах;

Дөрөв. Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, аймаг, нийслэлийн засаг дарга нарт:

4.1. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах түлш, нүүрсний нөөцийг шаардлагатай хэмжээнд бүрдүүлэх, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах, эрсдэлийг тооцоолж авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөлт хийж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

4.2. Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, чанар, хүртээмжид тогтмол хяналт тавих, хөндлөнгийн хяналтыг сайжруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

Тав. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Ганбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Бямбацогт, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн нарт:

5.1. Улсын хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийг тогтвортой хэмжээнд хангах, хомсдол үүсгэхгүй байхад анхаарч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

5.2. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байгаа алслагдсан сумдад түлш, шатахууны тасалдал, хомсдол үүсэж байгаа тул орон нутаг руу түлш, шатахууны нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг импортлогч аж ахуйн нэгжүүдтэй хамтран яаралтай авч хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллах;

5.3. Эрчим хүч, дулааны эх үүсвэрүүдийн нүүрсний нийлүүлэлтийг хангаж байгаа “Багануур”, “Шарын гол”, “Шивээ Овоо” зэрэг нүүрсний уурхайн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангах 10-15 хоногийн түлшний нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлэх, цаашид нөөцийг таслахгүй байх арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлэх;

Зургаа. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга, Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

6.1. Гамшгийн улмаас учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, цаг хугацаа алдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор өвөлжилт хүндэрч болзошгүй зарим аймгийн малчдад улсын нөөцөөс өвс, тэжээл тодорхой нөхцөлтэйгээр олгох болон аймаг орон нутгийн Онцгой комисст шаардлагатай хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, гамшиг, ослын голомтод үүрэг гүйцэтгэсэн албан хаагчдын томилолт, шатахууны зардлын асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулж, шийдвэрлүүлэх;

Долоо. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Ганхүү нарт:

7.1. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Чинзоригт: Аймаг, сумдын эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй автомашины нарийвчилсан судалгааг гаргаж, өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэн сумдын эрүүл мэндийн төвд туулах чадвартай машин томилгоожуулах зэрэг зохион байгуулалтын арга хэмжээг эрүүл мэндийн салбарын хэмжээнд авч хэрэгжүүлэх, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх;

7.2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Э.Ганхүүд: Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх төлөвтэй байгаа тул нэн тэргүүнд тусламж, дэмжлэг үзүүлэх иргэд, тэдгээрийн хэрэгцээ шаардлагын судалгааг аймаг, сумдаар нь гаргаж, тогтмол шинэчлэх, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах;

Найм. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын дарга С.Ням-Эрдэнэд:

8.1. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч буй үед өвс, тэжээлийн зохиомол хомсдол, үнийн хөөрөгдөл үүсгэж байгаа эсэх асуудалд холбогдох хууль, журмын хүрээнд хяналт тавьж, зохих арга хэмжээг авч хэрэгжүүлэх, Улсын онцгой комиссыг шаардлагатай мэдээ, мэдээллээр хангаж ажиллах;

Шийдвэрийн биелэлтийг тооцож, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

